



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 635

Улаанбаатар хот

**“Геологийн судалгааны төв”
төрийн өмчит үйлдвэрийн газрын
2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин,
хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Геологийн судалгааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг 1 дүгээр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үйлдвэрийн газрын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн 2021 оны бизнес төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг захирал Н.Ганболдод үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА


Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн
635 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ
ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		2021 оны төлөвлөгөө	Харьцуулалт	
				Төлөвлөгөө	Хүлээгдэж буй гүйцэтгэл		2021 төл-2020 ХБГ	2021 төл-2020 ХБГ
1	Нийт орлого	мян.төг	12,301,360.4	5,126,613.2	5,137,654.8	5,294,542.2	103.1	156,887.4
	Геологийн хайгуулын ажил	мян.төг	12,300,360.4	4,676,613.2	4,687,654.8	4,385,451.3	93.6	(302,203.5)
	Өрөмдлөгийн ажил	мян.төг	-	450,000.0	450,000.0	909,090.9	202.0	459,090.9
	Бусад орлого	мян.төг	1,000.0	-	-	-	-	-
2	Нийт зардал	мян.төг	9,510,620.2	4,997,828.9	4,993,892.6	5,119,830.1	102.5	125,937.5
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	534,662.0	643,442.1	615,861.4	611,687.7	99.3	(4,173.7)
3	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	2,790,740.2	128,784.3	143,762.2	174,712.1	121.5	30,949.9
4	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	2,502,931.7	115,905.9	129,386.0	157,240.9	121.5	27,854.9
5	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	2,217,144.0	1,374,822.2	1,667,504.5	1,219,570.3	73.1	(447,934.2)
6	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	375,439.8	17,385.9	19,407.9	23,586.1	121.5	4,178.2
7	Нийт ажиллагсдын тоо	хүн	120	132	130	125	96.2	(5.0)
8	Нийт цалингийн сан	мян.төг	1,850,645.5	2,256,718.0	2,244,536.4	1,905,309.7	84.9	(339,226.7)
9	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	1,285.2	1,424.7	1,438.8	1,270.2	88.3	(168.6)
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.77	0.97	0.97	0.97	99.5	(0.0)
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	337,378.0	496,500.0	496,500.0	704,800.0	-	208,300.0
12	Нийт авлага	мян.төг	201,831.0	201,832.0	440,726.3	466,596.3	105.9	25,870.0
13	Нийт өглөг	мян.төг	431,732.0	154,000.0	210,160.0	168,000.0	79.9	(42,160.0)
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	431,732.0	154,000.0	210,160.0	168,000.0	79.9	(42,160.0)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны 12 дугаар сарын 08 -ны өдрийн 635
 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



**"ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2021
 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (мян.төг)	Нийт үнэ (мян.төг)
1	Өрөмдлөгийн суурь машин	ш	1	500,000.0	500,000.0
2	Фургон автомашин	ш	2	40,000.0	80,000.0
3	Хэвлэгч	ш	2	24,900.0	49,800.0
4	Санхүүгийн программ	ш	1	75,000.0	75,000.0
	Нийт үнэ				704,800.0 (Долоон зуун дөрвөн сая найман зуун мянган төгрөг)